

МОНГОЛЫН ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь Монголын Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо (цаашид “Холбоо” гэнэ)-ны гишүүнчлэлтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Холбооны гишүүнээр журмын 2-т заасан шаардлагыг хангасан хувь хүн болон хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр элсэнэ.
- 1.3 Холбоо нь гишүүддээ зориулсан үйл ажиллагаагаа хуулийн тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хүртээмжтэйгээр, ёс зүйтэй явуулна.
- 1.4 Холбооны гишүүнчлэлийн бүртгэлийг Удирдах зөвлөлийн даргын удирдлагад ажиллах зохицуулагч ажилтан хариуцна.

Хоёр. Гишүүнчлэл

- 2.1 Холбоо нь мэргэжилтний болон байгууллагын гишүүнчлэлтэй байна.
- 2.2 Мэргэжилтний гишүүнчлэлд 2.3-д заасан шаардлага хангасан дээд боловсролтой хувь хүн элсэнэ.
- 2.3 Мэргэжилтний гишүүнчлэл нь дараах төрөлтэй байна.

1) Жинхэнэ гишүүн:

I. Хөдөлмөрийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, хөдөлмөрийн эрүүл мэнд судлаач эмч, сувилагчийн төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн
Эсвэл
- Их дээд сургуулийг хөдөлмөрийн эрүүл мэнд-аюулгүй байдлын мэргэжлээр төгссөн
Эсвэл
- Хөдөлмөрийн эрүүл ахуй, хөдөлмөрийн эрүүл мэндийн чиглэлээр судалгаа хийж, магистр, докторын зэрэг хамгаалсан.

II. Хөдөлмөрийн эрүүл ахуйтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагаа эрхэлдэг

2) Энгийн гишүүн:

I. Хөдөлмөрийн эрүүл эрүүл ахуйн мэргэжлийн суурь мэдлэгтэй дараах мэргэжилтнүүд

- Нийгмийн эрүүл мэнд судлалч, Эрүүл ахуйч
Эсвэл
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан
Эсвэл
- Үйлдвэр, байгууллагын эмч
Эсвэл
- Бусад чиглэлийн мэргэжилтэй

II. Хөдөлмөрийн эрүүл ахуйтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагаа эрхэлдэг

3) Залуу гишүүн:

I. Нийгмийн эрүүл мэнд, эрүүл ахуй-тархвар судлал, хөдөлмөрийн эрүүл ахуй, хөдөлмөрийн эрүүл мэнд-аюулгүй байдлын мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа бакалаврын оюутан

Эсвэл

II. Дээрх чиглэлээр мэргэжил эзэмшсэн шинэ төгсөгч (их сургууль төгссөнөөс хойш 1 жилийн хугацаанд)

4) Хүндэт гишүүн: Холбооны Удирдах зөвлөлийн шийдвэрээр олгоно.

2.4 I. Хөдөлмөрийн эрүүл ахуйн салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан мэргэжилтэн Байгууллагын гишүүнчлэлд хөдөлмөрийн эрүүл ахуй, ХАБЭМ-ийн мэргэжлийн байгууллага, бусад эрүүл ахуйн мэргэжлийн чиглэлийн байгууллагууд хамрагдаж болно.

Гурав. Гишүүдийн эрх ба үүрэг

3.1 Холбооны гишүүд нь дараах нийтлэг үүрэгтэй.

- 1) Монголын Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбооноос баталсан “Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдөнө.
- 2) Холбооны гишүүнчлэлийн хураамжийг жил бүр төлөх үүрэгтэй. Хүндэт гишүүн нь энэхүү хураамжаас чөлөөлөгдөнө.
- 3) Холбооноос зохион байгуулдаг сургалтын үйл ажиллагаанд оролцож, өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх үүрэгтэй.
- 4) Холбооны нэрийн өмнөөс аливаа үйл ажиллагаанд оролцохоос өмнө Удирдах зөвлөлд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна.
- 5) Холбооны гишүүдээс мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан талаарх мэдээллийг баримт нотолгоотойгоор Удирдах зөвлөлд нэн даруй мэдээлэх үүрэгтэй. Мэдээлэл өгсөн хүний нэрийг нууцлана.

3.2 Холбооны гишүүд нь дараах нийтлэг эрхтэй.

- 1) Холбооны үйл ажиллагаанд оролцох, холбооноос хариуцан гүйцэтгэж буй төрөл бүрийн ажлын хэсгүүдэд өөрийн мэргэшил, ур чадвар, ажлын туршлагын чиглэлээр ажиллах эрхтэй
- 2) Холбооны нийт гишүүд Удирдах зөвлөлийн гишүүнийн сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй.
- 3) Удирдах Зөвлөлийн шийдвэрт нь хяналт тавих эрхтэй.
- 4) Холбооноос гишүүдэд зориулан бэлтгэдэг мэдээллийг хүлээн авах, сургалтад хамрагдах эрхтэй.
- 5) Холбооны үйл ажиллагаа, түүний тайлангийн талаарх санал, хүсэлтээ гишүүнчлэл хариуцсан ажилтанд тавих, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл авах эрхтэй.

3.3 Жинхэнэ гишүүн нь холбооны дүрмийн дагуу Удирдах зөвлөлийн гишүүний сонгуульд нэрээ дэвшүүлэх эрхтэй.

3.4 Байгууллагын гишүүн нь ХАБЭМ-ийн асуудал хариуцсан 6 хүртэлх ажилтнаа холбоонд бүртгүүлэн, үйл ажиллагаанд нь оролцуулах эрхтэй.

3.5 Байгууллагын гишүүн нь гишүүнчлэлийн бүртгүүлсэн ажилтнаа жилд 2 удаа солих эрхтэй.

Дөрөв. Гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг сунгах, гишүүнчлэлээс гарах

4.1 Холбооны гишүүнээр элсэх мэргэжилтэн болон байгууллага нь mnah.mn сайт дахь бүртгэлийн маягтыг бөглөнө. Гишүүнчлэл хариуцсан ажилтан гишүүнчлэлийн бүртгэлийн маягтыг хянаж, тохирох гишүүнчлэлийн төрөлд хувиарлана.

4.2 Гишүүнээр элсэх хувь хүн “Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийг бүрэн уншиж, дагаж мөрдөх амлалтаа өгнө.

- 4.3 Гишүүнээр элсэх хувь хүн эсвэл байгууллага нь хураамжаа бүрэн төлснөөр гишүүнчлэл нь хүчин төгөлдөр болно.
- 4.4 Холбооны гишүүн бүрт давтагдахгүй бүртгэлийн дугаарыг олгоно. Гишүүн нь холбооны үйл ажиллагаанд оролцохдоо бүртгэлийн дугаараа ашиглана. Гишүүнчлэлийн төрлөөс хамаарч бүртгэлийн дугаарын өмнө товчлолыг англиар үсгээр бичнэ.

Жинхэнэ гишүүн	FLL (full member)
Энгийн гишүүн	RGL (regular member)
Залуу гишүүн	YNG (young member)
Хүндэтг гишүүн	RSP (respected member)

Бүртгэлийн дугаарын загвар: гишүүнчлэлийн төрлийн товчлол, он – бүртгүүлсэн дэс дугаар. Жишээ нь 2017 онд 55 дахь жинхэнэ гишүүнээр бүртгүүлсэн бол бүртгэлийн дугаар **FLL17-55** болно.

- 4.5 Жил бүрийн 1 дүгээр улиралд багтаж гишүүнчлэлийн хураамжаа төлснөөр хувь, байгууллагын гишүүнчлэл нь сунгагдаж, холбооны бүх үйл ажиллагаанд оролцох эрх нь нээгдэнэ. Гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг холбооны Удирдах зөвлөл батлана.
- 4.6 Холбооны гишүүн хураамжаа төлөөгүй тохиолдолд эсвэл өөрийнх нь хүсэлт гаргаснаар гишүүнчлэлийг дуусгавар болно.

Тав. Гишүүдэд үзүүлэх дэмжлэг

- 5.1 Холбооны зүгээс гишүүдэд дараах нийтлэг дэмжлэгийг үзүүлэх ба үүгээр хязгаарлагдахгүй.
- 1) Мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх,
 - 2) Салбарын хууль тогтоомж, дүрэм журам, стандартын шинэчлэлийн мэдээллийг вэб сайт, имэйл, нийтийн сүлжээгээр дамжуулан гишүүдэд хүргэж, саналыг нь нэгтгэн холбогдох байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх,
 - 3) Холбооны гишүүний хүсэлтээр гишүүн болох тодорхойлолт албан бичгийг үйлдэх,
 - 4) Холбооноос хэрэгжүүлж буй стандартын шинэчлэл, судалгаа, бусад төсөлд ажилд оролцуулах,
 - 5) Хөдөлмөрийн эрүүл ахуйн үндэс цахим сургалтад үнэгүй хамруулах
 - 6) Хөдөлмөрийн эрүүл ахуйн тасралтгүй сургалтад 30%-ийн хөнгөлттэй үнээр хамруулах,
 - 7) Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн ур чадварыг үнэлж, баталгаажуулах,
 - 8) Гишүүдийн уулзалт, хурал зохион байгуулах
 - 9) Холбооны гишүүдийн хооронд ажил мэргэжлийн шинжтэй мэдээлэл, зар түгээх

Төгсөв.